## ХУРАЛДААНЫ ТОЙМ

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ АРВАНЗУРГААДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны зургаадугаар сарын 15 -ны 14 цаг 15 минутад эхэлж, 16 цаг 35 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж 2 цаг 20 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|---|---|
| 1 | Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах Комиссын танилцуулга /Удирдах албан тушаалтанд дүгнэлт гаргах, нээлттэй сонгон шалгаруулалтын дүн, тайлан/ | |
| 2 | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын даргын сонгон шалгаруулалтыг хойшлуулахаар шийдвэрлэв. |
| 3 | Үндэсний хөгжлийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Үндэсний хөгжлийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны даргын сонгон шалгаруулалтыг хойшлуулахаар шийдвэрлэв. |
| 4 | Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга зэрэг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/30 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн:<br>Өлзийбатын Баттулгыг Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэн, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн |

| | | |
|---|---|---|
| | | нарийн бичгийн дарга /Б.Нямаа/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.<br>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/31 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн:<br>1. Гантөмөрийн Түвдэндорж, Орсоогийн Лхагвацэдэн нарыг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх<br>2. Гантөмөрийн Түвдэндоржийг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Нямаа/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 5 | Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/48 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус |

| | | |
|---|---|---|
| | | тус үндэслэн : Янсангийн Эрдэнэчимэгийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Гаалийн ерөнхий газрын дарга /Б.Асралт/- д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 6 | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хяналт- шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/49 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: Баатарын Батбилэгийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /О.Алтансүх/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 7 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн бодлого, зохицуулалтын Систем нэгтгэлийн албаны даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “б”, Сонгон шалгаруулах комиссын Д/50 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 15-ны |

| | | |
|---|---|---|
| | | өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: Лхагвасүрэнгийн Энхбатыг Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн бодлого, зохицуулалтын хэлтсийн Систем нэгтгэлийн албаны даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга /Б.Чинбат/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 8 | Хүний Эрхийн Үндэсний Комиссын Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “б”, Сонгон шалгаруулах комиссын Д/51 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: Өлзийсумъяагийн Ундрахыг Хүний Эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүний Эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны дарга /Ч.Алтангэрэл/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 9 | Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг эрчимжүүлэх зорилгоор "цахим хуудаст байршуулах шаардлагатай мэдээ мэдээлэл"-ийн тухай | Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2, мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"- 1.3, 3.7.1, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар |

| | | |
|---|---|---|
| | | тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.2.3, 5.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:<br>1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор “Мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар сурталчлах Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны тухай мэдээ, мэдээлийн жагсаалт”-ыг хавсралтаар батлах.<br>2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Салбар зөвлөлийн дарга нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Д.Баатарсайхан/-нд тус тус даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН**
**АЖЛЫН АЛБА**